



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 1/23

Сант сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр тус сумын харьяат асан Дамдины үр хүүхэд, ач зээ нарын санаачилгаар “Баян хайрханы тахилга” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах Их нас, дааганы уралдаанд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнх-Эрдэнэ

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Золбаяр

(Хушаат багийн Засаг дарга)

Ж.Оюунбат

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ж.Лхагважаргал

(Сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгч,
ахлах дэслэгч)


Э.Мөнгөншагай

(Сумын хэв журмын цагдаа, дэслэгч)

Э.Булганаа

(Сайхан сум дахь цагдаагийн хэлтсийн гэр
бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)

2. “Хурдан морины уралдааны дүрэм”-ийн дагуу уралдааны зохион байгуулалтад онцгой анхаарч, унаач хүүхдийн аюулгүй байдлыг сайтар хангаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Н. Доржбаяр
Хянасан: Ч. Дэвнэрэг
Хувь: 2